



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 461

Мандалговь

Орчны тохижилтыг сайжруулах жил
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 01 сарын 05-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтан Мандалговь хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн хандлагыг өөрчилж, бүх нийтийн оролцоотойгоор ААНБайгууллага, айл өрх, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд тохилог, цэвэр орчныг бүрдүүлэх зорилгоор 2022 оныг “Орчны тохижилтыг сайжруулах жил” болгон зарласугай.

2. “Орчны тохижилтыг сайжруулах жил”-ийн төлөвлөгөөг батлуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, үе шаттайгаар аян зохион байгуулж үр дүнг тооцож олон нийтэд сурталчлахыг сумын Засаг даргын орлогч (И.Эрдэнэцог), ХТГазрын дарга (Д.Очбадрах), холбогдох мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Зорилтот жилийн хүрээнд хийгдэх арга хэмжээнд шаардагдах зардлыг уул уурхай, ААНБайгууллага, иргэд, малчдын хандив, дэмжлэг, төсөл хөтөлбөрөөр санхүүжүүлж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

4. Идэвхи санаачлагатай оролцсон ААНБайгууллага, айл өрх, иргэдийг шагнаж, урамшуулан хагас, бүтэн жилээр дүгнэж, шаардагдах санхүүжилтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулахыг Санхүүгийн алба (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

5. Хоггүй, өнгө үзэмжтэй, тохилог орчин бий болгоход санаачлагатай ажиллахыг ААНБайгууллага, айл өрх, иргэдэд уриалсугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ



D:/document /Zasagdarga/ A.Zahiramj .doc 01.05

4822010000